

## АРДЧИЛЛЫГ ШИНЭЭР БОЛОН СЭРГЭЭН ТОГТООСОН ОРНУУДЫН ОЛОН УЛСЫН V БАГА ХУРАЛ

Монгол Улс. Улаанбаатар хот 2003 оны  
есдүгээр сарын 10-12

### **УЛААНБААГАРЫН ТУНХАГЛАЛ** Ардчилсан Засаглал ба Иргэний Нийгэм

**i. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хуралд хуран цугларсан Засгийн газрууд, даян дэлхийн улс үндэстний төлөөлөгчид бид,**

ii. Ардчилсан засаглал нь хууль ёсны бөгөөд мэдрэмжтэй, төлөөлөл болон оролцоог хангасан, ил тод бөгөөд хариуцлагатай, эрх болон хуульт ёсонд үндэслэсэн тогтолцоо мөн. Энэхүү засаглал эрх мэдэл олгохын сацуу түүнийг урвуулан ашиглахаас сэргийлж, хүний эрх, хүйсийн тэгш байдлыг дэмжин хамгаалж, хууль ёсыг дээдлэн хүндэлдэг эрх мэдлийн бие даасан, харилцан тэнцвэртэй байдлыг бий болгоно. Бид олон улсын хүний эрхийн болон олон улсын хүмүүнлэгийн эрхзүйн баримт бичгүүдийг соёрхон батлах, зөвшөөрөн дагах буюу тэдгээрт нэгдэн орох талаар хүчин чармайлт гаргах болно гэдгийг зарлан тунхаглаж;

iii. Ардчилал нь засгийн газруудын үйл ажиллагааг удирдлагад нь байгаа ард түмний хүсэл зорилгод үндэслүүлэх замаар тэдгээрийн хууль ёсны байдлыг хангаж, удирдан жолоодуулагч ард иргэдийн эрч хүчийг дайчлах замаар үндэсний хөтөлбөрүүдийн аугаа их амжилт ололтыг цогцлуулан, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийн нөөц чадавхийг дээшлүүлж, санал зөрөлдөөнийг хууль ёсны, хүчирхийллийн бус хэлбэрээр илэрхийлэх хэтийн төлөвийг бий болгох замаар хүний аюулгүй байдалд тус дөхөм үзүүлдэг;

iv. Мөн иргэний нийгмийн бүрэн дүүрэн, идэвхтэй, саад тогторгүй оролцоо нь ардчилсан, хүчирхийллийн бус арга хэрэгслийг ашиглагдаараа ардчилсан засаглалын байгууллагууд ямагт, түүний дотор сонгуулиудын хооронд ард түмнийхээ хүсэлт, шаардлагад мэдрэмжтэй хандаж байхад нь чухал хэрэгцээтэй хэмээн мэдэгдэж;

v. Өнөөдөр ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнууд дотоодын болон олон улсын хүчнүүдийн бий болгосон олон олон бэрхшээл, сорилттой тулгарч байгаа ба сүүлийн гучин жилд олон оронд ардчилал түргэн урагшилсан боловч ардчилсан байгууламж цэргийн буюу улс төрийн шинжтэй тогтворгүйжүүлэгч хүчнүүдийн шууд аюул заналд өртөөд буйн жишээг олж харж байгааг хүлээн зөвшөөрч;

vi. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын өмнө бүрэн эрхт байдал, ардчилсан ололт амжилтаа бэхжүүлж, ардчиллыг эргэлт буцалтгүй үйл явц болгох, нийгмийн бүх гишүүд ардчилах үйл явцаас ашиг хүртэж, засаглалын шинэ тогтолцоонд бүрэн дүүрэн оролцож чадахуйц байдлыг хангах зорилт мөн тулгарч байгааг бас хүлээн зөвшөөрч;

vii. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын (АШСТО) олон улсын анхны бага хурлаас хойш 15 жил өнгөрсөн болоод энэ он жилүүдэд ардчилал түүнийг шинээр болон сэргээн тогтоож байгаа олон улс оронд хөгжин батжиж ирсний зэрэгцээ зарим улс оронд ардчилал нь зэвсэгт мөргөлдөөн, зохион байгуулалттай гэмт хэрэг, харгис болон террорист ажиллагаанаас болж бүтэлгүйтэж байсныг эргэн санаж;

viii. Өнгөрсөн хугацаанд олон улсын терроризм газар авсныг бид харж байна. Түүнийг таслан зогсоох талаар улам өсөн нэмэгдэж буй олон улсын хүчин чармайлтыг бид бүрэн дэмжиж байна. Бид терроризмын бүхий л үйлдэл, арга, ажиллагааны аливаа хэлбэр, илрэлийг дахин давтан буруушаан зэмлэж байна. Энэ талаар терроризмаас сэргийлэх, түүнтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа, түүний дотор хэт даврах үзэл, хүчирхийллийг дэмжин тэтгэж байгаа хүчин зүйлсийг үгүй болгох арга хэмжээ шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай цохон тэмдэглэж байна. Ийм хүчин чармайлт нь олон улсын эрхзүй, ялангуяа олон улсын хүний эрх, дүрвэгсэд болон хүмүүнлэгийн эрхзүйн дагуу хүлээсэн үүрэгт нийцэх учиртай гэдгийг дахин сануулж,

ix. Өмнө дурдсан бэрхшээл сорилтуудыг мөн хүлээн зөвшөөрч, эв нэгдэл, хамтын ажиллагааны үзэл санааны дагуу ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудыг бэхжүүлэх, түүнчлэн нийгмийн бүх гишүүдийн ашиг тусын тулд ардчилсан өөрчлөлт шинэчлэлт хийж байгаа бусад орнуудыг дэмжих замаар дэлхий нийтийн ардчилсан хөдөлгөөнийг цаашид бэхжүүлэн хүчирхэгжүүлэх зам мөрийг нээхийг эрмэлзэж, ардчиллын тогтвортой байдлыг хангаж, хууль, эрхзүйн үндэс суурийг тавихын тулд түүнийг төрт улсуудын Үндсэн хуульд суулгаж өгөх ёстойг тэмдэглэж,

х. - 1988 оны зургадугаар сард Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын анхдугаар бага хурлаас гаргасан Манилын Тунхаглал;

- 1994 оны долдугаар сард Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын хоёрдугаар бага хурлаас гаргасан Манагуагийн Тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөр;

- 1997 оны есдүгээр сард Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын гуравдугаар бага хурлаас гаргасан “Байдлын тойм ба зөвлөмжүүд” хэмээх төгсгөлийн баримт бичиг болон

- 2000 оны арван хоёрдугаар сард Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын дөрөвдүгээр бага хурлаас гаргасан Котонугийн Тунхаглалд зарчим болон үүрэг амлалтыг дахин нотолж,

xi. - Ардчилсан орнуудад бусдаас дээгүүр хэмээн бидний үздэг нэлээд чанар, ялангуяа оролцоо болон төлөөллийг хангасан, шуударга ёсны шинжид хамаатай чанарууд бий;

- Ардчилал, хөгжил болон хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдал харилцан шүтэлцээтэй, бие биенээ дэмждэг бөгөөд Ардчилал бол зогсолтгүй үргэлжилсэн үйл явц мөн гэдгийг мөн хүлээн зөвшөөрч,

xii. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудад ардчиллыг бэхжүүлэн гүнзгийрүүлэхэд нь туслахад хүчин чармайлтаа зориулна.

xiii. Дараах зарчмуудыг баталж, энэхүү бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх олон улсын, бүс нутгийн болон үндэсний Үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн дагуу эдгээр зарчмыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллахаар тохиров.

xiv. НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчмуудад үнэнч байхаа дахин нотолж, олон улсын олон талт гол чуулга болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагыг бэхжүүлэх үүрэг амлалтаа цохон дурдаж байна.

## **I. Ардчилсан нийгэм бол шудрага, хариуцлагатай нийгэм мөн.**

1. Шудрага, хариуцлагатай нийгэм нь ядуурлыг үл тэвчих ба манай нийгэмд байгаа тэгш бус байдлыг арилгаж, адил тэнцүү боломжийг дэмжих чиглэлд ажиллах болно.

1.а Бид бидний тус тусын нийгмийн бүх гишүүд ашиг тусыг нь хүртэх тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлтийг дэмжих талаар бүхий л хүчин чармайлт гаргана.

1.б Бид нийгмийн бүх гишүүдэд эрүүл мэндийн тусламж, боловсрол, цэвэр усны хангамж, ариун цэврийн үндсэн үйлчилгээ болон боломжийн эрчим хүч болон харилцаа холбоо гэх мэт нийгмийн үндсэн үйлчилгээг үзүүлэх чармайлт тавина.

1.в Бид нийгмийн ядуу дорой, хөдөөгийн болон мэргэжилгүй гишүүдэд даяарчлал сөрөг бус, нааштай нөлөө үзүүлэх

явдлыг хангах талаар хүчин чармайлт гаргана.

2. Шудрага, хариуцлагатай нийгэм нь нийгмээс гадуурхагдмал иргэддээ шаардлагатай бол олон улсын хамтын нийгэмлэгийн туслалцаатайгаар нийгмийн хамгааллын сүлжээ бий болгоно.

2.а Бид эдийн засгийн шинэтгэл болон технологийн шинэчлэлтийн улмаас цомхотголд орсон ажилчдыг дахин мэргэшүүлэхийг чармайна.

3. Шудрага, хариуцлагатай нийгэм нь тогтвортой хөгжлийг чухалчилна.

3.а Бид хөгжлийн үйлчилгээ үзүүлэхэд хөдөөгийн хөгжлийг чухалчилж, хот, хөдөөгийн ялгааг арилгах үүрэг хүлээж байна.

3.б Бид байгаль орчны асуудлуудыг нэн даруй шийдвэрлэх үүрэг хүлээж байна.

3.в Бид Мянганы хөгжлийн Зорилтуудад хүрэхэд туслах хүчин чармайлт гаргана.

4. Шудрага, хариуцлагатай нийгэм нь хүний аюулгүй байдал болон хүний хөгжлийг эрхэмлэнэ.

4.а Бид эдийн засаг, нийгэм болон улс төрийн дэвшилд хүрэхийн тулд хүний аюулгүй байдлыг бэхжүүлж, хүний хөгжлийг урагшлуулах үүрэг хүлээж байна.

4.б Бид хүний аюулгүй байдал болон хүний хөгжлийн чухал хэсэг болсон улстөрийн чөлөөт байдал болон оролцоог дэмжиж, боловсрол, эрүүл мэндэд хөрөнгө оруулах, хүчирхийллийн аюул заналаас ард түмний ангид байдлыг сайжруулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах болон ардчилсан засаглалаар дамжуулан оролцоог хангах зэрэг нь манай нийгмийг илүү сайн сайхан ирээдүйд хүргэх бие биеэ тулж дэмжсэн зарчмууд мөн гэдгийг дахин нотлож байна.

4.в Бид хүний аюулгүй байдал, хүний хөгжлийн дээрх үндсэн зарчмуудыг тус тусын орны үндэсний хөгжлийн стратегидаа тусгах үүрэг хүлээж байна.

## **II. Ардчилсан нийгэм бол бүх талын оролцоог хангасан нийгэм мөн.**

5. Бүх талын оролцоог хангасан нийгэм нь үндэсний хэмжээнд шийдвэр гаргах үйл явцад иргэдээ оролцох боломжоор хангасан байх ёстой.

5.а Бид өөрсдийн байгууллага тогтолцоогоо ардчиллын зорилгод илүү сайн үйлчлэх байдлаар засч залруулах хүчин чармайлт гаргана.

- 5.б Бид төлөөллийн ардчилал болсон парламентын болон сонгуулийн тогтолцоогоо бэхжүүлэх хүчин чармайлт гаргана.
- 5.в Бид сонгуулийн үйл явцад эмэгтэйчүүдийн бүрэн оролцоо, хууль тогтоох байгууллагуудыг оролцуулан бүхий л түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх явдлыг хөхүүлэн дэмжих боломжийн бүхий л арга хэмжээг авах үүрэг хүлээж байна.
- 5.г Бид шаардлагатай тохиолдолд чөлөөт, шударга, ээлжит сонгуулийн зарчмыг дэмжих үүднээс улс төрийн намууд болон иргэний нийгмийн холбогдох давхарга, хэсгүүдийн оролцоотойгоор сонгуулийн шинэтгэл хийх болно.
- 5.д Бид сонгуулийн байгууллагуудын хараат бус байдлыг хангах, сонгуулийн сурталчилгаа болон явцыг бие даасан шинжээч мэргэжилтнүүдийн тусалцаатайгаар хянах ба сонгуулийн сурталчилгаанд зориулсан хандивыг ил тод байлгах үндсэн дээр өөрсдийн сонгуулийн тогтолцоог бэхжүүлэх үүрэг хүлээж байна.
- 5.е Бид ард түмний оролцоо болон төлөөллийг нэмэгдүүлэхийн тулд өөрсдийн орны олон намын ардчилсан тогтолцоог цаашид бэхжүүлэх хүчин чармайлт гаргана.
- 5.ё Бид улс төрийн намуудын хөгжлийн эрхзүйн хүчирхэг үндэс суурийг тавих, улстөрийн хөгжил болон сонгуульд тэднийг оролцуулах, нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэх зэрэг таатай нөхцөл бүрэлдүүлэхийг өөрийн үүрэг гэж үзнэ.
- 5.ж Бид ард түмэн парламентын гишүүдтэйгээ харьцах илүү боломж олгох механизмыг бүрдүүлнэ.
- 5.з Бид зохих ёсоор зөвлөлдсөний дараа л хууль гаргаж байх боломжийн бүхий л арга хэмжээг авах болно.
- 5.и Бид ардчиллыг орон нутгийн түвшинд бэхжүүлэх хүчин чармайлт гаргана.
- 5.к Бид тус тусын нийгмийн бүхий л давхарга, хэсгийг, ялангуяа хилийн чандад буюу гадаадад амьдардаг иргэдээ хамруулахын тулд сонгуулийн оролцоог өргөтгөх арга хэмжээ авна.

6. Бүх талыг хамарсан оролцоо бүхий нийгэм нь үндэстний болон бусад цөөнхөд хамаарах ард түмний эрх ашиг, сонирхлыг хөндсөн асуудлуудыг шийдвэрлэнэ.

6.а Бид цөөнхөд хамаарах ард түмэнтэй тэдний байдлыг сайжруулах талаар нээлттэй яриа хэлцээ хийж байх үүрэг хүлээж байна.

6.б Бид үндэсний бүх байгууллага тогтолцоонд цөөнхийн бодит сайн төлөөллийг бүрдүүлэх, ингэх боломжгүй нөхцөлд тогтмол зөвлөлдөх боломжоор хангах үүрэг хүлээж байна.

7. Бүх талыг хамарсан оролцоо бүхий нийгэм нь нийгмийн гаралтай мөргөлдөөнийг зохицуулах, ардчилсан орнуудын бат тогтвортой байдлыг бэхжүүлэх харилцан зөвшилцөл болон эвлэрлийг дээдэлж хэрэгжүүлнэ.

7.а Бид мөргөлдөөнийг зохицуулах, тогтвортой байдлыг дэмжих, ард иргэдийн бүтээлч эрч хүчийг нийтийн үйл хэрэгт хандуулах түгээмэл хэрэгсэл болсон эвлэрэл, зөвшилцлийн замаар ардчиллын олсон ололт амжилтыг талархан дэмжиж байна.

8. Бүх талыг хамарсан оролцоо бүхий нийгэм нь нийгмийн бүх гишүүд болон бүлгүүдийн үндэсний нэгдэл нягтралыг хөхүүлэн дэмжих учиртай.

8.а Бид нийгмийн бүх бүлгийн үндэсний нэгдэл нягтрал болон үндэсний өвөрмөц төрх байдлыг дэмжих хүчин чармайлт гаргана.

9. Бүх талыг хамарсан оролцоо бүхий нийгэм нь ардчиллын үнэт зүйлсийн талаарх боловсролыг хөхүүлэн дэмждэг бөгөөд ардчиллыг бэхжүүлэх хүчин чармайлтынхаа нэг хэсэг болгож ардчилсан эрх болон эрх чөлөөний талаар нийгмийн гишүүддээ мэдээлнэ.

9.а Бид ардчиллын үндсэн үнэт зүйлс, хүний эрхийн талаарх мэдлэгийг сайжруулах үндэсний боловсролын хөтөлбөрүүдийг боловсруулж эхлэх буюу тус дөхөм үзүүлэх буюу эрх бүхий зохих байгууллагуудын зүгээс үүнийг хийхийг хөхүүлэн дэмжих чармайлт тавина.

### **III. Ардчилсан нийгэм бүх иргэдийнхээ эрх, эрх чөлөөг дэмжин хамгаална.**

10. Ардчилсан нийгэм нь эрхийг гажуудуулах болон эрх мэдлээ урвуулан ашиглах явдлыг засч залруулах хэрэгслийг бий болгох замаар бүх иргэдийнхээ эрх, эрх чөлөөг дэмжин хамгаална.

10.а Бид ардчиллын үндсэн зарчим болон хүний эрхийг бүрэн хүндэтгэж баталгаажуулах явдлыг хангахын тулд үндэсний байгууллага тогтолцоо болон механизмыг буй болгон бэхжүүлэх үүрэг хүлээж байна.

10.б Бид хүний эрхийг гажуудуулсан буюу эрх мэдлээ урвуулан ашигласан хэнийг ч болов эрх зүйн байдал буюу албан тушаалыг үл харгалзан улс орондоо мөрдөж байгаа

хуулийн хүрээнд шүүхээр хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээж байна.

11. Бүх гишүүдийнхээ эрх, эрх чөлөөг дэмжин хамгаалдаг нийгэм нь хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн хүндэтгэхийн төлөө ажилладаг хүмүүсийг хамгаална.

- 11.а Бид одоо мөрдөж байгаа Хүний эрхийн гэрээ, конвенциудын дагуу хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаанд таатай орчинг бүрдүүлэх үүрэг хүлээж байна.
- 12. Ардчилсан нийгэм нь эмзэг бүлгийнхнийг хамгаална.
  - 12.а Бид ялангуяа зэвсэгт мөргөлдөөний үед хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан болон тахир дутуу иргэдтэй хатуу ширүүн, доромжлон харьцахаас хамгаалах талаархи асуудлуудыг шийдвэрлэх үүрэг хүлээж байна.
  - 12.б Бид эмэгтэйчүүд, залуусын байдлыг сайжруулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх үүрэг хүлээж байна.
  - 12.в Бид хүүхэд, хөгшид болон тахир дутуу хүмүүсийн байдлыг сайжруулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх үүрэг хүлээж байна.

#### **IV. Ардчилсан нийгэм бол нээлттэй, ил тод нийгэм мөн.**

13. Нээлттэй, ил тод нийгэм нь мэдээлэл чөлөөтэй бүрдүүлэх, эрэлхийлэх болон түгээхийг хөхүүлэн дэмждэг.

- 13.а Бид хэвлэл, нэвтрүүлэг болон Интернет зэрэг бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг хангахад шаардлагатай хууль, эрх зүйн аливаа шинэтгэл хийх үүрэг хүлээж байна.
- 13.б Бид хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулахын зэрэгцээ ийм эрх чөлөөг урвуулан ашиглах явдлаас хувь хүн, байгууллага, байгууллага тогтолцоог хамгаалах үүрэг хүлээж байна.
- 13.в Бид бүх хүн ардад мэдээллийн шинэ технологи ашиглах боломж олгох үүрэг хүлээж байна.
- 14. Нээлттэй ил тод нийгэм нь орон нутгийн, үндэсний болон олон улсын байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн үр нөлөөтэй оролцоог хангадаг.
  - 14.а Бид ардчилсан хөгжлийнхөө түнш болсон иргэний нийгмийн байгууллагуудтай тогтмол, идэвхтэй яриа хэлцээ өрнүүлж, харилцан зөвлөлдөхөд оролцох үүрэг хүлээж байна.
  - 14.б Бид иргэний нийгмийн байгууллагуудын хөгжих эрхзүйн болон зохицуулалтын үндсийг тавих, таатай орчин



бүрдүүлэх үүрэг хүлээж байна. Бид иргэний нийгэм болон засгийн газар хоорондын түншлэлийг дэмжин урагшлуулах болно. Энэ зорилгоор бид орон нутгийн болон үндэсний түвшинд шийдвэр гаргах үйл явцад иргэний нийгмийн байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулах үүрэг хүлээж байна.

- 14.в Бид засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдийн талаар илүү мэдээлэл өгөх, хэрвээ байхгүй бол мэдээллийн тухай хууль тогтоомж болон мэдээллийн тогтолцооноос хүртэх өгөөж ашгийг авч үзэх замаар иргэддээ үйлчлэх үүрэг хүлээж байна.

**V. Ардчилсан нийгэм нь тохиолдож болох сорилт, бэрхшээлийг үл харгалзан хүлээн зөвшөөрсөн эрх зүйн хэм хэмжээ болон хариуцлагын зарчмын дагуу үйл ажиллагаа явуулна.**

15. Хүлээн зөвшөөрсөн эрхзүйн хэм хэмжээ болон хариуцлагын зарчмын дагуу үйл ажиллагаа явуулдаг нийгэм нь терроризмын бүхий л хэлбэрийн гэмт хэрэг, үндэсний болон олон улсын энх тайван ба аюулгүй байдал, мөн ардчилсан засаглалд учрах аюул гэж үзэж зэмлэн буруушаадаг.

- 15.а Бид терроризмын эсрэг тэмцэхдээ олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан хүний эрх, үндсэн эрх чөлөөг дэмжин хамгаалах явдлыг хангах үүрэг хүлээж байна. Бид терроризмын хэрэгт яллагдаж буй этгээдийг шүүх зохистой ажиллагааг хангах үүрэг хүлээж байна. Бид олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс НҮБ-ын ивээл дор терроризмын асуудлыг шийдвэрлэх талаар тавьж буй хүчин чармайлтыг дэмжиж, ийм үйл явц эрчимжинэ гэдэгт итгэж буйгаа илэрхийлж байна.

- 15.б Бид терроризмын эсрэг тэмцлийнхээ хүрээнд шударга, эрх тэгш тогтвортой, аюулгүй нийгмийг байгуулахад чухал үүрэгтэй ардчилал, хүний эрх, сайн засаглал, хөгжил болон хууль ёсыг дэмжин урагшлуулах үүрэг хүлээж байна.

- 15.в Бид терроризмын эсрэг тэмцлийнхээ хүрээнд терроризмын бүх хэлбэрийн эсрэг тэмцлийг хүчтэй болгох, олон улсын болон үндэсний хэмжээний мөргөлдөөнийг эв зүйгээр зохицуулах явдлыг хангахын тулд олон улсын эрхзүйг бэхжүүлэх чиглэлд хамтран ажиллах үүрэг хүлээж байна.

- 15.г Бид шаардлагатай бол нийгэмдээ мөргөлдөөнөөс сэргийлэх болон зөвшилцөл буй болгох арга механизмыг бий болгож,



нэвтрүүлэх үүрэг хүлээж байна.

16. Хүлээн зөвшөөрсөн эрхзүйн хэм хэмжээ болон хариуцлагын зарчмын дагуу үйл ажиллагаа явуулдаг нийгэм нь ардчилсан замаар сонгогдсон засгийн газрын эсрэг хүч хэрэглэсэн болон цэргийн самуун дэгдээхийг үл тэвчинэ.

16.а Бид цэрэг, цэрэгжүүлсэн болон цагдаагийн хүчнийхэн ардчилал болон үндсэн хуульт ёсыг хамгаалж, үйлдлээрээ ардчилсан замаар сонгогдсон дэглэмийг бусниулахгүй байх явдлыг хангах үүднээс тэдэнд иргэний хяналт тогтоох үүрэг хүлээж байна.

16.б Бид ардчилсан замаар сонгогдсон засгийн газруудын эсрэг босон тэмцэгчидтэй хууль ёс болон үндсэн хуулийн дагуу харьцах үүрэг хүлээж байна.

17. Хүлээн зөвшөөрсөн эрхзүйн хэм хэмжээ болон хариуцлагын зарчмын дагуу үйл ажиллагаа явуулдаг нийгэм нь авилгал болон эрх мэдлээ урвуулан ашиглахыг үл тэвчинэ. Эдгээр үзэгдэл нь ардчилсан засаглалд итгэх ард түмний итгэлийг эвдлэг учраас ардчиллыг эвдлэн бусниулна.

17.а Бид эрх мэдлийн хуваарилалтад тулгарах аливаа асуудлыг нэн даруй шийдвэрлэж байх үүрэг хүлээж байна.

17.б Бид шүүх байгууллагын хараат бус, голч байдал, мэргэжлийн чадварыг хангах баталгааг бэхжүүлэх үүрэг хүлээж байна.

17.в Бид авилгалыг устгах болон итгэл эвдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг нэвтрүүлэх тогтолцоо болон журмыг засч залруулах, өөрчлөн шинэчлэх буюу сэргээн тогтоох үүрэг хүлээж байна.

17.г Бид авилгал, эрх мэдлээ урвуулан ашигласан талаарх мэдээллийг мөрдөн шалгах явдлыг хөхүүлэн дэмжих үүрэг хүлээж байна.

## **VI. Ардчилсан нийгэм бусадтайгаа эв санаа нэг байдаг.**

18. Ардчилалд шилжихэд хааяагүй хүндрэлтэй байгаа бусад улс орныг дэмжин, туслалцаа үзүүлэх.

18.а Ардчиллын замыг сонгож авсан болон ардчиллын байгууллага тогтолцоог бий болгосон туршлага, сургамж болон сайн практикаа хуваалцах.

18.б Олон талт байгууллагуудын ардчиллыг урагшлуулах, бэхжүүлэх талаархи хүчин чармайлтыг дэмжих.

19. Бид 2002 оны арван нэгдүгээр сард болсон Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сөүдийн бага хурлын үр дүнг тэмдэглэж,

дэлхий даяар ардчиллыг хөгжүүлэн гүнзгийрүүлэх нийтлэг зорилгыг хангах үүднээс хоёр чуулга уулзалт ойртон нягтрах явдлыг хөхүүлэн дэмжиж байна.

20. Ардчилсан нийгэм уг үндсээрээ оролцооны болон төлөөллийн шинжтэй учраас Мянганы хөгжлийн Зорилгыг ханган биелүүлэх илүү чадвартай гэдэгт бид итгэж байна. Ардчилагдан хөгжиж буй орнуудад амьдарч байгаа бүх хүн ардын тусын тулд илүү чинээлэг ардчилсан улсууд нь ардчиллыг шинээр болон сэргээн тогтоож байгаа орнуудад туслах шаардлагатай. Учир нь ийм туслалцаа тогтвортой байдлыг хангаж өгснөөрөө ардчилах үйл явцыг амжилтад хүргэх юм.

20.а Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудад Мянганы хөгжлийн Зорилгод хүрэхэд нь туслалцаа үзүүлэх.

20.б Бүс нутгийн болон олон улсын чуулга уулзалтууд дээр авсан үүрэг амлалтаа биелүүлэхэд нь ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудад туслалцаа үзүүлэх.

21. Бид Ардчиллын шинээр болон сэргээн тогтоосон орнуудын таван удаагийн бага хурлыг зохион байгуулах боломж олгосон Филиппин, Никарагуа, Румын, Бенин болон Монгол улсын Засгийн газруудад, мөн НҮБ болон хандивлагч орон тус бүрт талархлаа илэрхийлж байна. Бид НҮБ-ын Ерөнхий Ассамблей болон түүний гишүүн орнуудад хандан НҮБ-тай хамтран зохион байгуулах АШСТО-дын бага хурлуудад цаашид дэмжлэг үзүүлэх боломжийг авч үзэхийг хүсч байна.

22. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын тавдугаар бага хурлыг амжилттай зохион байгуулсан Монгол Улсын Засгийн газрын хүч чармайлтыг бага хуралд оролцогчид өндрөөр үнэлж, гүн талархал илэрхийлэв. Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт тайван замаар шилжсэн арван гурван жилдээ ардчиллын үнэт зүйлсийг хөгжүүлэн бэхжүүлэхэд үлэмж амжилт олсныг оролцогчид сайшаан тэмдэглэв.